

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2009 оны тувадугаар сарын 03

№9 (582)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

141.	Дагвадоржийн Ганбаатар, Цэрэнгийн Хэнмэдэх нарт Улсын тод манлай уяач цол олгох тухай	Дугаар 23	130
142.	Улсын манлай уяач цол олгох тухай	Дугаар 24	130
143.	Улсын алдарт уяач цол олгох тухай	Дугаар 25	131
144.	Одвогийн Балжинийнамд Монгол Улсын ардын баги цол хүртээх тухай	Дугаар 27	131
145.	Жамбалын Хатанбаатарт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай	Дугаар 28	131
146.	Намсрайн Сүүдэд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 29	131
147.	Чултамийн Батсхайжанд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 30	132
148.	Ядамсүрэнгийн Шаарийнбууд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 31	132
149.	Цэдэн-Ишийн Няндагт Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 32	132
150.	Лувсандашийн Жижгидсүрэнд Монгол Улсын эрзүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 33	132
151.	Гомбын Балданд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 34	133
152.	Будрагчагийн Даши-Эндонд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 35	133
153.	Хавтгайн Намсрайд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 36	133
154.	Цэндийн Нямдоржид Монгол Улсын гавьяат хуульын цол хүртээх тухай	Дугаар 37	133
155.	Чимиддоржийн Ганзоригт Монгол Улсын гавьяат эдийн засаг цол хүртээх тухай	Дугаар 38	134
156.	Налгарын Эрдэнэцогтод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 39	134
157.	Эрэндоржийн Доржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 40	134
158.	Түгэлхүүгийн Баасансүрэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 41	134
159.	Чагнаадоржийн Ухнаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 42	135
160.	Гонгоосурэнгийн Оюунболдод Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай	Дугаар 43	135
161.	Сүрэнгийн Отгоннямд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 44	135
162.	Балжинийнмyn Осоржамаад Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай	Дугаар 45	135
163.	Манаалжавын Шагдарсүрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 46	136
164.	Зумбын Чантууд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 47	136

165.	Гэндэнковын Отгонпүрэвт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртэх тухай	Дугаар 48	136
166.	Бадамын Байгалмаад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртэх тухай	Дугаар 49	136
167.	Гелгээгийн Наранцэрэгт Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан цол хүртэх тухай	Дугаар 50	137
168.	Хүрлээгийн Болормаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртэх тухай	Дугаар 51	137

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

169.	Төрийн албаны тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдо заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 01	137
170.	Гурав. ЯАМ АГЕНТЛАГАЙН АКТ	Дугаар 113	143

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар сарын 20-ны өдөр	Дугаар 23	Улаанбаатар хот
-------------------------------------	-----------	-----------------

**Дагвадоржийн Ганбаатар, Цэрэнгийн
Хэнмэдэх нарт Улсын тод манлай
үяач цол олгох тухай**

Монгол Улсын "Үндэсний их баяр наадмын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.6, 8.8 дахь заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

Монгол түмний цагцэлийн манлай-Үндэсний их баяр наадмын болон шигшмэл, бүсийн хурдан морины уралдаануудад эрдэнэт хүлгийнхээ уяа сойлгыг тааруулан түрүү магнай авч, айрагдуулан

наадамч олноо баягасан Говь-Алтай аймгийн Баян Уул сумын харьят, "Макс" группын өрөнхийлög Монгол Улсын манлай үяач Дагвадоржийн Ганбаатар, Төв аймгийн Сэргээлэн сумын харьяа; Монгол Улсын манлай үяач Цэрэнгийн Хэнмэдэх нарт Улсын тод манлай үяач цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар сарын 20-ны өдөр	Дугаар 24	Улаанбаатар хот
-------------------------------------	-----------	-----------------

**Улсын манлай үяач цол
олгох тухай**

Монгол Улсын "Үндэсний их баяр наадмын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.6, 8.8-д заасан болзлыг хангасан дор дурдсан үяачдад "Улсын манлай үяач" цол олгосугай.

1. Цогтын Батсайхан - Төв аймгийн Батсүмбэр сумын харьят Монгол Улсын алдарт үяач

2. Банзрагчийн Билэгдэмбэрэл - Төв аймгийн Лүн сумын харьят Монгол Улсын алдарт үяач

3. Дашицэрэнгийн Одгэрэл - Төв аймгийн Баянцогт сумын харьят Монгол Улсын

алдарт үяач

4. Бат-Очирын Эрдэнэгэрэл - Сэлэнгийн Сүхбаатар сумын харьят Монгол Улсын алдарт үяач

5. Дамбадаржаагийн Эрдэнэчулзуун - Дүгнэвийн аймгийн Луус сумын харьят Монгол Улсын алдарт үяач

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯА



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2009 он №9 (582)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

Улсын алдарт уяач цол олгох тухай

Монгол Улсын "Үндэсний их баяр наадмын тухай" хуулийн 8 дузаар зүйлийн 8.3, 8.6, 8.8-д заасан болзлыг хансан дор дурдсан уяачдад "Улсын алдарт уяач" цол олгосугай.

1. Нямдэлзийн Баатар - Сэлэнгэ аймгийн Каахлант сумын харьж уяач
2. Чилхасурэнгийн Гансух - Сүхбаатар

аймгийн Дарьганга сумын харьж уяач
3. Лхамдэгдийн Олонбаяр - Баянхонгор аймгийн Баянлиг сумын харьж уяач
4. Тундэвийн Энхтайван - Нийслэлийн Налайх дүүргийн уяач

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

Одвогийн Балжиннямд Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Биенийн тамир, спорт, батлан хамгаалахын албарт олон жил санаачилга, үр бутээлтэй ажиллаж, үндэсний болон бусад бөхийн төрлөөр зилдэг тамирчыг сургах дасгалжуулан улс, олон яз, тив, дэлхийн хэмжээний тэмцээнд амжилттай ропцуулж, Зэвсэгт хүчинд биенийн тамир, спортыг

хөгжүүлэхэд оруулсан бодитой хувь нэмрийг нь үзүүлж Зэвсэгт хүчиний "Алдар" спорт хорооны дарга, хурандаа Одвогийн Балжиннямд Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар
хот

Жамбалын Хатанбаатарт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай

Зруул мэндийн салбарт олон жил үр үзэлтэй ажиллаж, монголын уламжлалт анагаах хувьтэй орчин үеийн эмчилгээний арга жиллагаатай хослуулсан эзэгийн очванийн эмчлэх инэ арга технологийг бий болгон эмчилгээнд үр үнтэй нэвтрүүлж, эрдэм шинжилгээний бие даасан үзэл, ном товхимот бичиж нийтлүүлэн, памжлалт болон спортын анагаах ухааныг

хөгжүүлэхэд оруулж байгаа онцгой хувь нэмрийг нь үзүүлж Уламжлалт анагаах ухааны Эзэг судалын клиникин төвийн ерөнхий захирал, доктор, профессор Жамбалын Хатанбаатарт Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

Намсрайн Сувдад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон ил үр бутээлтэй ажиллаж, үндэсний болон энгэдэгжүүжиг, уран сайхны киноны гол дуруудийг эргэжлийн ёндер түвшинд чадварлаг бүтээж, эзлэгийн залгамж халаа, мэргэжлийн уран тээлчдийг бэлтгэх; Монолын сөйл урлаг түүний этор театр, киноны урлагийг хөгжүүлэх, дэлхий

дахинд сурталчлахад оруулсан бодитой хувь нэмрийг нь үзүүлж Улсын драмын эрдмийн театрын дэд захирал Намсрайн Сувдад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар
 хотЧүлтээмийн Батсайханд Монгол Улсын
ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллан ардын уламжлалт урлагийн гайхамшигт бүтээн морин хуурьн баялаг эсвэл санг чадамгай эзэмшиж, үндэсний болон гадаадын сонгодог хөгжлийн бүтээлмийг мэргэжлийн ёндер түвшинд хөгжимдэж, Монголын хөгжлийн урлагийг хөгжүүлэх, сурталчлан дэлгэрүүлэхэд

оруулсан бодитой хувь нэмрийг нь үнэлж Үндэсни дуу бужийн эрдмийн чуулганы гоцпол хөгжимийн морин хуурч Чүлтээмийн Батсайханд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар
 хотЯдамсүрэнгийн Шаарийбууд Монгол Улсын
гавьяат багш цол хүртээх тухай

Дээд боловсролын салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, сургалт-судалгаа, эрдэм шинжилгээний олон ном, сурх бичиг түүрвийж, Монгол, манж судлал, япон хэл шинжлэлээр дотоод, гадаадын мэргэжилтэн, багш, судлаач эрдэмтдийг бэлтгэх, Монгол дахь манж, япон

сүдлэлээг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн хүндэт профессор Ядамсүрэнгий Шаарийбууд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар
 хотЦэдэн-Ишийн Няндагт Монгол Улсын
Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн
цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухааны салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, сурган хүмүүжүүлэх ухааны шинж онол, үзэл баримтлал дэвшүүлсэн эрдэм шинжилгээний бүтээлүүд түүрвик, боловсролын шинжлэх ухааны хөгжүүлэх, сурган хүмүүжүүлэх ухааны залуу эрдэмтэн, судлаач, багш нарыг сургах бэлтгэхэд оруулсан

хувь нэмрийг нь үнэлж "Зорилго тэвчээс сургуулийн эрдэм шинжилгээний удирдагч, доктор профессор Цэдэн-Ишийн Няндагт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар
 хотЛувсандашийн Жигжидсүрэнд Монгол Улсын
эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан
цол хүртээх тухай

Эрүүл мэнд, боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан сургалт, эрдэм шинжилгээний бүтээлүүд түүрвик, эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч, боловсон хүчиний бэлтгэх, тэднийг давтсан сургах, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа, удирдлагын менежментийг сайкруулах, хүн амын эрүүл мэндийг

хамгаалахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж ЭМШУИС-ийн Мэргжил дээшлүүлэх институти зөвлөх, доктор Лувсандашийн Жигжидсүрэн Монгол Улсын эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2009 он №9 (582)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Гомбын Балдан Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад он удаан жил
ур бүтээлтэй ажиллан орон нутгийн сургуулийн
материаллаг баазыг бэхжүүлж, сургалтын арга
зарилыг боловсронгуй болгон чанар, стандартыг
сангах, сургачдын авьяас чадварыг хөгжүүлэх,
ялуу багш нарыг сургаж дадлагажулахад
эруулсан хувь нэмрийг нь үнэлж Овхэрхангай

аймгийн Есэнзүйл сумын дунд сургуулийн ахмад
багш Гомбын Балдан Монгол Улсын гавьяат багш
цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

Будрагчаагийн Даш-Эндонд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухааны болон төрийн
ахиргааны төв байгууллагад олон жил үр
үзээлтийн ажиллаж, нийгэм, улс төр, түн ухааны
иглэлээр эрдэм шинжилгээ, сургалт судалгааны
омоохон бүтээлүүд түрүүж, сургалт, эрдэм
жинжилгээний ажлын үр нелөөг дээшлүүлэх,
蒙古 төрийн бодлогыг боловсруулж

хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж
ШУА-ийн Философи, социологи, эрхийн
хурээлэнгийн садийн удирдагч, доктор, профессор
Будрагчаагийн Даш-Эндонд Монгол Улсын шинжлэх
ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

Хавтгайн Намсрайд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухаан, боловсролын салбарт олон
ил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, орчин үеийн
изийкийн салбарт эзлэх бөөм-квант орны онолын
иглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны гарамгай
үтээл түрүүж, шинжлэх ухааныг хөгжүүлэх,
эдэм шинжилгээний залуу ажилтан, эрдэмтдийг
үргаж бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж

ШУА-ийн Физик техникийн хурээлэнгийн онолын
физикийн секторын эрхэлгэч, академич Хавтгайн
Намсрайд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат
зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

Цэндийн Нямдоржид Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр олон
даа сонгогдон ажиллаж, хууль хяналтын
зүйгүүллагуудын үйл ажиллагааны эрх зүйн
цэсийг шинчлэх, төрийн бодлого боловсруулах,
туль тогтоох үйл ажиллагааг боловсронгуй болгон
их зүйт төрийг төлөвшүүлэх, парламенттэй ёсиг

хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж УИХ-
ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод харгийн сайд Цэндийн Нямдоржид Монгол
Улсын гавьяат хуульч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2009 он №9 (5)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
 хот

Чимиддоржийн Ганзоригт Монгол Улсын
гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Монгол Улсын Засгийн газраас гадаадын эзэл тусламжийн хөрөнгийг авч ашиглах болон геологи, эрдэс баялгийн салбарын талаар баримтлах бодлогыг боловсруулах, татвар, гаалийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ОХУ-тай хийх их ерийн асуудлыг шийдвэрлэх, Монгол-Оросын хамтарсан ўйлдвэрүүдийн гэрээ, хэлээнцээрийг шинчлэх. Монгол Улсын төсвийн

орлогыг бүрдүүлэх, санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь узэл Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт ўйлдвэр" ХХ-ийн сренийн захирагийн Чимиддоржийн Ганзоригт Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
 хот

Налгарын Эрдэнэцогтод Монгол Улсын
гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллан сургалт-судалгаа, эрдэм шинжилгээ, ўйлдвэрлэлийн шилдэг бүтээлүүд түүрвик, хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтийг боловсон хүчинийг сургаж бэлтгэх, дээд боловсролыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг

нь узэлж ХААИС-ийн Экологи, технологи хөгжлийн сургуулийн захираг, доктор, профессор Налгарын Эрдэнэцогтод Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар
 хот

Эрэндоржийн Доржид Монгол Улсын урлагийн
гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагуудад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллан мэргэжлийн урлагийн байгууллагыг чадварлагараар удирдах, уран бүтээлийн чанарыг сайжруулан урын санг баяжуулж, уран бүтээлчдийн үр чадварыг дээшлүүлэх, циркийн урлагийг хөгжүүлэх,

сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь узэлж "ACA" циркийн түйцэтгэх захирагийн Эрэндоржийн Доржид Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүтэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
 хот

Тугалхүүгийн Баасансүрэнд Монгол Улсын
соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээлэл, гадаад харилцааны салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж угта зохиол, сэтгүүл зүй, эрдэм шинжилгээ-судалгааны чиглэлээр шилдэг ном зохиол бичиж түүрвин, Монголын утга зохиол, сэтгүүл зүйн салбарыг хөгжүүлэхэд оруулсан хувь

нэмрийг үзэлж "МОНЦАМЭ" агентлагийн даргын сэтгүүлч Тугалхүүгийн Баасансүрэнд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯА



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2009 он №9 (582)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
 хот

Чагнаадоржийн Ухнаад Монгол Улсын
хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил
санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, уян дурангийн
ба хэт ашиан оношлогооны орчин үеийн дэвшилтэй
яргуудыг эмнэлгийн практикт анхлан нэвтрүүлж,
эношлогоо, эмчилгээний чанар, үр дүнг сайжруулан
тун амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж
Байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын клиникийн

нэгдсэн II эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн дэд
захирал, клиникийн профессор Чагнаадоржийн
Ухнаад Монгол Улсын хүний гавьяат эмч цол
хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар
 хот

Гонгоосурэнгийн Оюунболдод Монгол Улсын
гавьяат дасгалжуулагч цол хүртээх тухай

Биеийн тамир, спортын салбарт олон жил
анаачилга, үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн
юолон сонирхогчдын боксын спортын тэрлеөр зэрэг,
олжтой тамирчдын сургах болтээн, дасгалжуулсан
чаг, тамирчдаа тив, дэлхий, олимпийн наадмын
эмцээнүүдэд амжилттай оролцуулж, мэргэжлийн
оксын спортыг хөгжүүлэхэд оруулсан хувь

нэмрийг нь үнэлж "Чингис" боксын клубийн захирал,
дасгалжуулагч Гонгоосурэнгийн Оюунболдод
Монгол Улсын гавьяат дасгалжуулагч цол
хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар
 хот

Сүрэнгийн Отгоннямд Монгол Улсын
гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Соёл урлагийн байгууллагад олон жил үр
үзэлтэй ажиллаж, дэлхийн сонгодог болон
чадсний балет, бүхийн жүжигийн гол дүрүүдийг
эргэжлийн ондер түвшинд, чадварлаг бүтээж,
蒙古л Улсад балет, сонгодог бүхийн урлагийг
эзжүүлэх, гадаад оронд сурталчлахад оруулсан

хувь нэмрийг нь үнэлж Улсын дуурь бүжгийн
эрдмийн театрин гоцлол бүхижчин Сүрэнгийн
Отгоннямд Монгол Улсын гавьяат жүжигчин цол
хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар
 хот

Балжиннямын Осоржамаад Монгол Улсын
гавьяат тээвэрчин цол хүртээх тухай

Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг
хтимол чанартай хийж, шатахуун, сэлбэг
эрэгслийн хэмнэлттэй ажиллаж, техник
двиглалтын хугацааг уртасган, машин техникийн
ийнгын бэлэн байдлыг хангаж, Төр, засгийн
ийгүүллагуудын тээврийн үйлчилгээний

албанад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг нь
үнэлж ТЗУААЭГ-ын харьяа Авто баазын жолооч
Балжиннямын Осоржамаад Монгол Улсын гавьяат
тээвэрчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 он №9 (5)

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар
хот

**Маналжавын Шагдарсүрэнд Монгол Улсын
хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, эрдэм шинжилгээ, судалгаа, орчуулгын бүтээлүүд тутувиж, эзгийн овчиний эмчлэх эмчилгээний шинэ аргыг практикт амжилттай нэвтрүүлж, эзгүүр судалж, эзгийн овчиний эмчлэх хувийн хэвшлийн анхны эмчилгээг байгуулж, удирдлага, менежментийн орчин үеийн арга барилыг чадамгай ашиглан эмчилгээний үйлчилгээний чанарыг сайжруулж, хүн

амын эрүүл мэндийг хамгаалахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Шагдарсүрэн" эмнэлгийг ерөнхий захирал, анагаах ухааны доктор профессор Маналжавын Шагдарсүрэнд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар
хот

**Зумбын Чантууд Монгол Улсын
аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Хүнсний аж үйлдвэрийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, үйлдвэрлэнд шинэ дэвшилтэй технологи нэвтрүүлэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, үйлдвэрийн хамт оныг чадварлаг удирдан зохион байгуулж, үндэсний хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд

оруулсан хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймгийг "Спирт бал бурам" ХК-ийн Спиртийн үйлдвэрийн дарга Зумбын Чантууд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар
хот

**Гэндэнжавын Отгонпүрэвт Монгол Улсын
гавьяат уурхайчин цол хүртээх тухай**

Уул уурхайн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, хариусан машин механизмын засвар үйлчилгээг чанартай хийж, техник ашиглалтын хугацааг уртасган, нүүрс опборлох даалгаврыг тогтолц давуулан биелүүлж, үйлдвэрлэнд тэргүүний арга барил, шинэ техник технологийг нэвтрүүлэн, уул уурхайн үйлдвэрлэлийг

хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Багануур" ХК-ийн экскаваторын машин Гэндэнжавын Отгонпүрэвт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯА

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 02 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар
хот

**Бадамын Байгалмаад Монгол Улсын соёлын
гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Соёл урлагийн байгууллагын удирдах ажилтнаар олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн урлагийн байгууллагуудыг зөв менежментээр удирдан зохион байгуулж, материаллаг баазыг бэхжүүлэн үйл ажиллагааг нь сайжруулж, Монголын соёл урлагийг дотоод, гадаадад сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Соёлын төв өргөөний ерөнхий захирал Бадамын Байгалмаад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯА



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 он №9 (582)

2009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар
хот

Гэлгээгийн Наранццэгт Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан цол хуртээх тухай

Худалдааны салбарт олон жил санаачилга,
р бүтээлтэй ажиллаж, худалдаа, үйлчилгээнд
эзвшилтэй арга ажиллагааг нэвтрүүлэн
эрэглэгчдэд хөнгөн шуурхай үйлчилгээг хүргэх,
үн амыг хүнсний бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний
враагваар хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Нийслэлийн худалдаа, үйлчилгээний
"Хишигдэлгэрэх" ХХК-ийн захирал Гэлгээгийн
Наранццэгт Монгол Улсын худалдааны гавьяат
ажилтан цол хуртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

009 оны 02 дугаар
арын 20-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар
хот

Хүрлээгийн Болормаад Монгол Улсын гавьяат жүжигчин цол хуртээх тухай

Соёл урлагийн салбарт үр бүтээлтэй
жиллэн үзэгч сонсогчдын сэтгэлд нийцсэн
хийольндууг поп хандлагатай болгон мэргжлийн
ндер түвшинд чадварлаг дуулж, уран
утзлийнхээ санг баяжуулан, Монголын дууны
злагийг хөгжүүлэх, ерийн орон төдийгүй гадаад

оронд сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг
нь үнэлж дуучин Хүрлээгийн Болормаад Монгол
Улсын гавьяат жүжигчин цол хуртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

009 оны 03 дугаар
арын 04-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Төрийн албаны тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, туүний удирдлагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд
удлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн
ирга Ж.Бямбадорж даргалж, Үндсэн хуулийн
цийн гишүүн Н.Жанцан /илтгэгч/, Ж.Амарсаннаа,
Наранчимэг, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй,
иргийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг
опцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
хүмид нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын
залдаанд өргөдөл гаргагч, иргэн Ц.Даваасүрэн,

Д.Ширэндэв болон Ш.Энхтер, Улсын Их Хурлын
итгэмжлэгдсэн төвлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн
Д.Дондог нар оролцов. Хуралдаанаар Төрийн
албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь
заалт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг
дэвсгэрийн нэгж, туүний удирдлагын тухай хуулийн
26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Үндсэн хуулийн
Арван зургадугаар зүйлийн 1, 2, Тавин есдүгээр зүйлийн 1,
2, Жардугаар зүйлийн 1, 2, Жаран хоёрдугаар



зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороонд оршин суугч, иргэн Ш.Энхтөр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөвөлдөө:

"Монгол Улсын Үндсэн хуульд нутгийн удирдлагыг "засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага" гэж томъёолоод удирдлагын хоёр эхлэлийг хослуулах үзэл баримтлалыг удирдлага болгосон. Энэ нь "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн вөрөө удирдах ёсиг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжин" гэсэн Үндсэн хуулийн заалт (Тавин есдүгээр зүйлийн 1 дахь хэсэг)-аар илрэч байгаа юм.

... Үндсэн хуульд орон нутгийн вөрөө удирдах ёсны байгууллагын турван үндсэн хэлбэрийг тодорхойлсон. Үүнд:

- а/. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөвлөгчдийн Хурал,
- б/. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал,
- в/. Иргэдийн Төлөвлөгчдийн Хурлын болон иргэдийн Нийтийн Хурлын тэргүүлэгчид.

Эдгээр нь орон нутгийн вөрөө удирдах ёсны байгууллага мөн гэдгийг Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн вөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөвлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн" гэсэн заалтаар баттаган тунхагласан.

...Нутгийн вөрийн удирдлагын анхан шатны нэгж болох баг, хорооны Иргэдийн нийтийн хурал нь вөрийн эрх хэмжээний асуудлыг бие даан шийдвэрлэх, нэгжийн удирдлагыг төрийн

удирдлагатай хослон хэрэгжүүлэх үүднээс бе хорооны Засаг даргыг хурлаасаа нэр давшүүлдээд шатны засаг даргавар томилуулдаг. Үүни Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт баг, хорооны Хурлаасаа нэр давшүүлж, аймаж нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, сүүдүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга, баг, хорооны Засаг даргыг харьяалж сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно" гэсэн заалтад баталгаажуулсан. Үндсэн хуулийн дээр дурдсан Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт засны дагуу би хорооны иргэдийн Нийтийн Хурал нь нутаг оронд нор хүндтэй, ажил амьдралын баялаг туршлагатай нэр хүнд бүхий итгэл даах чадвартай иргэнээс би хорооны засаг даргад нэр давшүүлж, томилуулж ирсэн бөгөөд энэ нь нутгийн вөрийн удирдлагатай бодитоор хэрэгжүүлэхэд чухал алхам болж байсан

Монгол Улсын Их Хурлаас 2008 оны дугаар сарын 6-ны едер баталсан Төрийн албан тухай хуульд намэлт, вөрчлөлт оруулах тухай хуульд заснаар баг, хорооны Засаг даргыг төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөөх, уг бодлогыг хэрэгжүүлэх ўйл ажиллагаатай төрийн захиргааны удирдлагвар хангах чиг үүр бүхий төрийн захиргааны албан тушаалтад хамруулсан төдийгүй баг, хорооны Засаг даргыг тухайн нэгжийн Нийтийн Хуралд оролцож байг иргэд төрийн албаны шалгантай төнцсөн иргэнээс нэр давшүүлж, нэр давшигчийг томилуулахаа томилох эрх бүхий албан тушаалтанд сан болгооэр заасан нь дээр дурдсан Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2. Жаран хөёрдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг ноцтой зөрчсон, Үндсэн хуульд халдсан заалтууд боллоо гэж үзэж байж Нэгэнт баг, хорооны Засаг даргыг төрийн захиргааны албан тушаалтад хамруулж байг болгооэр Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан Төрийн албан тушаалтад тай



ренхий шаардлага нь хуульд веөрөөр заагаагүй бол ухайн албан тушаалыг эрхлэх мэдлэг, боловсрол, уршлага, ур чадвартай, мэргэшсэн байх гэсэн шаардлага баг, хорооны Засаг даргад хамаарч айгаа болно.

...Төрийн албаны тухай хуульд заасан нэр урдсан шаардлага хангасан нэр дэвшигч байхгүй алтгааны улмаас Орон нутгийн сонгууль 2008 оны 7 дугаар сард явуулснаас хойш өнөөдөрийг хүртэлт аж, хорооны Засаг даргыг нэр дэвшүүлж, эмилтуулах асуудал шийдэгдэхгүй байгаа бөгөөд эхеэ талаар баг, хороонд Үндсэн хуулийн Тавин зүйлээр зүйлийн 1-д заасан "Монгол Улсын засаг хиргээ, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь тгийн вөрөө удирдах ёсиг төрийн удирдлагатай ислуулах үндсэн дээр хэрэгжинэ" гэсэн заалт рэгжихгүй байна.

...Иймд Төрийн албаны тухай хуулийн 7 гаар зүйлийн 7.1.12-ын "баг, хорооны Засаг дарга" сэн заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, үний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Баг, хорооны Засаг даргад хайн нэгжийн нийтийн хуралд оролцож байгаа гэд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэнийг, маг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад тухайн рал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын пөвлөгөч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг рлын хуралдаанд оролцсон иргэд, тоологчдийн олонхийн буюу 50-иас дээш хувийн нал авсан нэр дэвшигчийг томилуулахаар милох эрх бүхий албан тушаалтанд санал шигноно." гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, яслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, сум, тгийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн засаг дарга, баг, хорооны Засаг даргыг харьяалах и дүүргийн Засаг дарга тус тус дервен жилийн асаагаар томилно", мөн хуулийн Жаран

хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн вөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно" гэсэн заалтуудыг зөрчсөн байх тул дүгнэлт гаргаж өгнө үү" гэжээ.

Хоёр. Ховд аймгийн Жаргалант сумын Жаргалан багийн оршин суугч, иргэн Ц.Даваасүрэн, тус багийн оршин суугч, иргэн Д.Ширэндээ нар Үндсэн хуулийн цэцэд ируулсэн өргөдөлдөө:

"...Нэг. ...Улсын Их Хурлаас 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалтаар Баг хорооны Засаг даргыг Төрийн захиргааны албан тушаал түүний ангилалд оруулсан нь Баг хорооны Засаг дарга тухайн иргэдийн нийтийн хурлаас сонгогдох, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 1, 2, Жардугаар зүйлийн 1, 2, Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн тул... Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 1, 2, Жардугаар зүйлийн 1, 2, Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөн тухай асуудлаар,

Хоёр. ...Монгол Улсын Их Хурлаас 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт баг, хорооны засаг даргыг төрийн захиргааны албан тушаал, түүний ангилалд оруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн ...9-д заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхэд халдсан хүний эрх, эрх чөлөөг зорчиж байх тул... Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9, Тавин есдүгээр зүйлийн 1, 2 дахь заалтуудыг зөрчсөн тухай асуудлаар маргаан үүсгэн хянаж, дүгнэлт гаргаж өгнө үү" гэсэн байна.



Гурав. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

...Төрийн албаны тухай хуульд баг, хорооны Засаг даргын албан тушаалыг засаг төрийн төлөөлөгч болохын нь хувьд хууль тогтоомж, Засгийн газар, харьялах дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нехцел баталгааг нь тогтвортой байлгах, төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чадварыг бэхжүүлэх үүднээс төрийн улс төрийн албан тушаалын ангиллаас хасаж, төрийн захиргааны албан тушаалын ангилалд хамааруулсан.

Баг хорооны засаг даргын албан тушаалыг төрийн албаны нэг ангиллаас өөр ангилалд хамааруулсан боловч уг албан тушаалын иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшигдэн, дээд шатны буюу харьялах сум, дүүргийн Засаг даргаас 4 жилийн хугацаагаар томилогддог зарчим хэвээр хадгалагдаж байгаа болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсэгт Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүргэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьялах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьялах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томиллоо" гэсэн нийтлэг үндэслэлийг заасан боловч Баг хорооны засаг даргын томилогдож буй байдал нь бусад нэгжийн засаг дарга нарыг томилох зарчмаас агуулжин хувьд онцлог ялгаатай байдаг.

Ийм учраас орон нутагт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх анхан шатны нэгжийн хувьд баг, хорооны Засаг даргын албан тушаалыг улс төрийн

сонгуулийн үр дүнгээс үл хамааран Үндсэн хууль заасан 4 жилийн хугацаагаар чиг үүргэхэрэгжүүлэх нехцлийг бүрдүүлэх үүднээстүүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 4 дутгэс зүйлийн 4.2.5-д заасан "төрийн албан хаагчай бүрэн эрхээ хэрэгжүүлэх нехцел, баталгааг тэхангах" зарчмын хүрээнд төрийн улс төрийн албан тушаалаас төрийн захиргааны албан тушааль ангилалд хамааруулсан болно. Түүнчлэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэг түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан "Баг, хорооны Засаг даргын тухайн нэгжийн нийтийн Хуралд оролцож байж, иргэд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэни...дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаан оролцсон иргэд, төлөөлөгчийн олонхийн буюу 5 иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийн томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно." гэсэн зохицуулалт хийхдээс баг, хорооны засаг дарга нь тухайн ор нутагтаяа нэр хундтэй, ажил, амьдралын баян туршлагатай, нэр хүнд бүхий итгэл даах чадварт иргэн байхвас гадна харьялах нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргээ бүх засаг төрийн төлөөлөгч гэдэг утгаараа төрийн албаны тодорхой шалгуурыг хангасан байх зүйтэй гэж үзсэн юм.

Иймд дээр дурдсан нехцел байдал бол дараах үндэслэлээр Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүнчлэн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалт зарчсон гэж үзэх үндэслэлгүй байна.

...4. Монгол Улсын Үндсэн хуулийн Ажлын зургадугаар зүйлийн 9-д заасан "шууд бүх төлөөлөгчийн байгууллагааргаа уламжлан төрийн удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагаад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгогчийн эрхийг арван найман наснаас эзлэн. Сонгогчийн насыг төрийн зохих байгууллага, албан тушаалтадаас хамааран Үндсэн хуулийн 4 дутгэс зүйлийн 4.2.5-д заасан "төрийн албан хаагчай бүрэн эрхээ хэрэгжүүлэх нехцел, баталгааг тэхангах" зарчмын хүрээнд төрийн улс төрийн албан тушаалаас төрийн захиргааны албан тушааль ангилалд хамааруулсан болно. Түүнчлэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэг түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан "Баг, хорооны Засаг даргын тухайн нэгжийн нийтийн Хуралд оролцож байж, иргэд төрийн албаны шалгалт өгч тэнцсэн иргэни...дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг Хурлын хуралдаан оролцсон иргэд, төлөөлөгчийн олонхийн буюу 5 иас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийн томилуулахаар томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгоно." гэсэн зохицуулалт хийхдээс баг, хорооны засаг дарга нь тухайн ор нутагтаяа нэр хундтэй, ажил, амьдралын баян туршлагатай, нэр хүнд бүхий итгэл даах чадварт иргэн байхвас гадна харьялах нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргээ бүх засаг төрийн төлөөлөгч гэдэг утгаараа төрийн албаны тодорхой шалгуурыг хангасан байх зүйтэй гэж үзсэн юм.



авих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно” юсний зөрчсөн гэсэн талаар:

...Монгол Улсын Үндсэн хуулийн Сардугаар зүйлийн 2-т...заасны дагуу баг, хорооны асаг дарга нь иргэдийн Нийтийн Хурлаас нэр эвшин, харьялах сүм, дүүргийн Засаг даргаас эмилогддог зарчим хэвээр хадгалагдаж байгаа болно. Иймд тухайн орон нутгийн баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал зохиц шаардлагыг хангасан эгзнийг нэр дэвшүүлэх эрх нь нээлттэй байгаа юм.

5. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран ёрдугаар зүйлийн 2-т “Нутгийн өөрөө удирдах тийгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд автын байгууллага нь шийдвэрлэж үл болно...” снийг зөрчсөн гэсэн талаар:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг өвгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дугаар зүйлийн 26.2-т “Баг, хорооны Засаг даргад хайн нэгжийн нийтийн Хуралд оропцож байгаа гэд териин албаны шалгант өгч тэнцсэн иргэний маг, нийслэл, сүм, дүүргийн Засаг даргад тухайн раг дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын пеөлөгч тус тус нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд уг трлын хуралдаанд оропцсон иргэд, пеөлөгчийн олонхийн буюу 50-иас дээш хувийн нал авсан нэр дэвшигчийг томилуулахаар милох эрх бүхий албан тушаалтанд санал үгноно” гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран ёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Нутгийн өөрөө ярдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг эд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэвсэгийг зөрчж буй асуудал биш бөгөөд Териин үзүүлэлтийн 35 дугаар зүйлийн 35.1.9-д юсны дагуу Териин албаны төв байгууллага нь рийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгальны түгэргэжлийн зүй, зохион байгуулалтын удирдлагыг яхь” чиг уүргээ хэрэгжүүлэх бөгөөд харин тухайн хорооны иргэдийн Нийтийн Хурлаас хуульд өснөн шаардлагыг хангасан иргэнийг тилүүлахаар дээд шатны Засаг даргад санал тгох эрх нь зөрчигдэхгүй, уг бүрэн эрхийг нь дээд

шатны байгууллагаас шийдвэрлэх талаар зохицуулалтыг тусгаагүй болно.

Ингэснээр уг зохицуулалт нь Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно” гэснийг зөрчиж байгаа биш, харин ч уг нехцлийг хэрэгжүүлэх нэг баталгаа болж байна гэж үзэж байна.

Иймд 2008 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийт аймаг, нийслэл, сүм, дүүрэг, баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэх, томилох журмыг нэг адил зарчмаар хуульчилсан байна.

2. Баг, хорооны Засаг даргыг улс териин албан тушаалтын ангиллаас хасч, Териин захиргааны албан тушаалтын ангилалд оруулан Териин албаны шалгант өгч тэнцсэн иргэний баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлж, томилуулах санал оруулахаар хуульчилсан Териин албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.12 дахь заалт, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жардугаар зүйлийн 2 дахь хэсгийт заасан тухайн иргэдийн Нийтийн Хурлын баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, харьялах сүм, дүүргийн Засаг даргын баг, хорооны Засаг даргыг томилох бүрэн эрхийг явцууруулан хязгаарлаж, эдгэр бүрэн эрхэд Териин албаны төв байгууллага хөндлөнгөөс оролцох боломжийг бурдуулсан байна гэж үзэх үндэслэлтэй байна.



2.1.3. Мэдлэг, чадварын түвшин тогтоо шалгалтаар бүх хичээлүүдийн үнэлгээ 100 хувьтай шалгагдсан байх.

2.2. Суралцагч нь тухайн жилийн 9 дүгээр сарын 10-ны дотор сургуулийн захиргаанд анги алгасан суралцах хүсэлт гаргана.

2.3. Сургуулийн захиргаа нь анги алгасан суралцахаар хүсэлт гаргасан суралцагчийн асуудлыг багш нарын зөвлөгөөний хурлаар хэлэлцэж, тэдний санал, дүгнэлтийг үндэслэн суралцагчийн судалгааг тухайн оны 9 дүгээр сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Боловсролын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.4. Аймаг, нийслэлийн Боловсролын асуудал хариуцсан нэгж нь анги алгасан суралцах хүсэлтийг судлан үзээд мэдлэг, чадварын түвшин тогтоо шалгалаа өгч суралцагчийн нээсийг гаргаж, 9 дүгээр сарын 25-ны дотор сургуулиудад хүргүүлнэ.

2.5. Боловсролын асуудал хариуцсан нэгжийн даргын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг жил бүрийн 5 дугаар сарын 10-ны дотор тухайн сургуультай хамтран суралцагчийн алгасан суралцсан ангийн хичээлүүдийн агуулгаар мэдлэг, чадварын түвшин тогтоо шалгалаа авна.

2.6. Боловсролын асуудал хариуцсан нэгж нь шалгалтын дүн, сургуулийн захиргааны санал, дүгнэлтийг харгалзан суралцагчийг анги алгасуулан дэвшүүлэн суралцуулах асуудлаар эцэслэн шийдвэр гаргана.

Гурав. Шалгалтыг зохион байгуулах

3.1. Суралцагчийн мэдлэг, чадвар сургуулийн захиргааны шийдвэрээр томилогдсан шалгалтын комисс тогтоосон журмын дагуу үнэлгээ дүгнэнэ.

3.2. Энэхүү журмын 2.1 дүгээр зүйлд заас шаардлагыг хангасан суралцагчийг шалгалт оруулна.

3.3. Суралцагчаас алгасан суралцах анги сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдэд шалгалт авна.

3.4. Анги алгасан суралцагч сургуули захиргааны хоорондын харилцааг гарзээг зохицуулна.

3.5. Сургуулийн захиргаа, аймаг, нийслэлийн Боловсролын газраас суралцагчийн мэдлэг чадварын үр дүнг үнэлэх хондлонгийн үнэлгээ хэграфик, сургууль, багшийн зүтгээс суралцагч авах ўлчилгээ зэргийг гарзэнд тусгана.

3.6. Тухайн хичээлийн жилд анги алгасан суралцах суралцагчийн тоог бага, дүйнээр Боловсролын статистикийн мэдээлэлд зөвлөх тусгана.

3.7. Суралцагчийн хувийн хэргийн сурлаг дун, үнэлгээ гэсэн хэсэгт алгасан суралцах ангийн хичээлүүдийн үнэлгээг тэмдэглэх тодорхойлолт гэсэн хэсэгт тухайн анги хичээлүүдийн агуулгаар тогтоосон хугацаанаас өмнө бие даан эзэмшиж, анги алгасан суралцах тухай бичиглэл хийнэ.